



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар Б/29

Баян-Овоо сум

И.Уранцэцэгт ур чадвар олгох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт (төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам)-ын 2,3 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан А/35, А/10, 9 дүгээр тушаалын заалт, Хамтын гэрээний 2 дугаар зүйлийн 2.15.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ичинхорлоогийн Уранцэцэгт Монгол бичгийн тэргүүний уншигч шалгаруулах аймгийн ХХ уралдаанд бэлтгэсэн шавь амжилттай оролцож 1 байрт шалгарсан тул ур чадварын нэмэгдлийг 1 сарын хугацаатай үндсэн цалингийн 20%-аар тооцож олгосугай.
2. Ур чадварын нэмэгдлийг холбогдох хууль журмын дагуу 2026 оны 04 дүгээр сард олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ  Ч.БОЛОРМАА



2326010087